

# Н.РЕРИХИЙН БАЙШИН

## Ч.БОЛД

Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн “Отгонтэнгэр” их сургуулийн чанх ар талд хуучны нэгэн дүнзэн байшин бий. Нэг давхар энэ байшин нийслэлийн маань түүхэнд онцгой дурсгалтай. Тодруулж хэлбэл энэ байшинд Оросын аугаа их уран зураач, нэрт соён гэгээрүүлэгч Н.Рерих амьдарч байжээ. 1926 оны есдүгээр сараас 1927 оны тавдугаар сар хүртэл Монголд байх хугацаандаа энэ дүнзэн байшинд амьдарч байсан нэрт эрдэмтэн маань Төв Азийн нутгаар хийсэн алдарт аяллын бэлтгэлээ эндээс эхэлсэн түүхтэй.

Бараг 100 гаруй жилийн настай эл байшин түүх хүүрнэдэгсэн бол мөн ч ихийг өгүүлнэ дээ. Өдрөөс өдөрт өндөр өндөр байшин уралдан босож байгаа энэ цагт чухам ямар азаар бүрэн бүтэн үлдэж чадсаныг нь таахыг аргагүй. Харин энэ байшинг “нээж” олсон гавьяатан нь академич Ш.Бира ажээ. Тэрбээр хэдэн жилийн өмнө өөрийн багш Н.Рерихийн бичсэн “Дундад Азийн зөргөөр” хэмээх номыг уншиж суугаад алдарт эрдэмтэн Н.Рерих урд талд нь зогсч байгаа модон байшингийн зураг олж үзсэн аж. Хуучны дүнзэн байшин бүрэн бүтэн үлдэж хоцорсон гэдэгт төдийлөн итгэлтэй бус ч гэлээ эрж хайсаар олж харсан тэр мөчид Ш.Бира доктор магнай хагартлаа баярласан гэдэг. Уг байшинг нурван газрыг нь чөлөөлөх гэж байсан яг тэр үед нь хамгаалан үлдээсэн юм билээ. Тэрбээр эцэг хүү Рерихийн намтрын хуудсанд тод мөрөө үлдээсэн түүхэн дурсгалтай уг модон байшинг авран авч үлдэхийн тулд Олон улсын монгол судлалын холбоо, Монголын Рерихийн нийгэмлэгийн нэрийн өмнөөс Улаанбаатар хотын захиргаанд хамгаалалтад авах тухай хүсэлт тавьжээ. Өвгөн эрдэмтний



1926-1927 онд Н.Рерих энэ байшинд амьдарч байжээ.

буянтай үйлс сэтгэлчлэн бүтэж уг байшинг Улаанбаатар хотын соёлын дурсгалд бүртгэн авч Монголын Рерихийн нийгэмлэгийн мэдэлд шилжүүлсэн байна. Тус нийгэмлэг аав хүү Рерихийн шинжлэх ухаан, уран бүтээлийн өвийг судлах, олон нийтийн дунд тэдний хүмүүнлэгийн хийгээд соёлын үзэл санааг түгээн дэлгэрүүлэх ажил өрнүүлэхийн тулд эл дүнзэн байшинг сэргээн засварлаж гэр музей байгуулах зорилготой байгаа ажээ.

**Түүхэн дурсгалт байшинг сэргээн засварлах ажлыг эрхэлж байгаа зураач, барималч Д.Батдоржтой уулзаж ярилцсан юм.**

**-Энэ хэдэн онд баригдсан байшин бэ?**

-Баригдсан он цагийн хувьд яг тогтоож хэлэхэд хэцүү. XX зууны эхээр Хүрээнд баригдсан цөөн тооны орос хийцийн байшингуудын нэг. Цонжны янз хүрээ, хээ чимэглэл, барьсан хийц маяг зэргийг харахад тухайн үед Улаанбаатарт баригдаж байсан орос хийцийн дүнзэн байшингуудын нэг юм билээ. Бид Эрхүүгийн эртний дүнзэн байшингуудын зурагтай харьцуулж үзээд тэгж тогтоосон.

**-Суурь сайтай юм аа?**

-Суурийг Монголын Рерихийн ний-

гэмлэг шинээр бэхжүүлэн засч дотор талд нь шал зэргийг нь шинэчлэн уг байшинг сэргээх ажлыг эхлүүлсэн юм. Байшингийн урд хэсэг ерөнхийдөө гайгүй. Харин хойд хэсгээрээ ялзарч өмхөрснийг саяхан сэргээв.

**-Энэ байшинд эртний гэж хэлэхээр сонин содон зүйл үлдэж үү?**

-Байнаа. Хадаас нь гэхэд л дөрвөлжин хийцийн хадаас байна лээ. Байшингийн хойд хэсгийн өмхөрч муудсан дүнз моднуудыг буулгахад дан тийм хадааснууд гарч байна. Бас босоо пийшин, пийшингийнх нь хаалт аргагүй л хуучны эд байна лээ.

**-Хэдэн сард сэргээн засварлаж дуусгах төлөвлөгөөтэй вэ?**

-Зургадугаар сард дуусгаж хүлээлгэж өгөх ёстой.

Н.Рерихийн байшинг сэргээн засварлах төслийн санхүүжилтийг америкийн иргэн, бурханы шашин судлаач Канадын профессор Глеен Муллин хариуцан ажиллаж байгаа аж. Тэрээр “Бид цаашдаа Рерихийн гэр музей байгуулж, уран зургийн гайхамшигтай цуглуулгын дээжсээс авчирч Монголын олон нийтэд үзүүлж сонирхуулах бодолтой байгаа. Ботаникийн хүрээлэн, ХААИС зэрэг байгууллагууд цэцэрлэг зүлэгжүүлэлтийн ажлыг үнэгүй хийж өгье гэсэн” хэмээв.